



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/206

Чингис хот

Газар эзэмших эрхийн гэрчилгээг  
шилжүүлэх тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу “Суварга-Эв” ХХК-ийн (2035391)-ий эзэмшлийн Хэрлэн сумын 2 дугаар баг (Булаг), Баатрууд гудамжинд байршилтай үйлчилгээний зориулалттай 3209м<sup>2</sup> газрыг “Старкатеринг” ХХК (5504007)-д 44 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. “Старкатеринг” ХХК-ий эзэмшил газрын тойм зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олсон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Баярхүү)-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг “Старкатеринг” ХХК-ийн захирал Ш.Гаалиймаад үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/206 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ

231010506